МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 17 өдөр Дугаар А/248 Улаанбаатар хот

Түр заавар, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эрүүл мэндийн анхан шатны байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээний түр заавар"-ыг нэгдүгээр, "Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эрүүл мэндийн анхан шатны байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний бүдүүвч"-ийг хоёрдугаар, "Коронавируст халдвар (COVID-19)-ын үед гэртээ тусгаарлагдсан иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлж, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал), Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл (Д.Мягмарцэрэн)-д тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

141200877

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04
дүгээр сарын 17 өдрийн А/293 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(COVID-19)-ЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЗААВАР

Нэг. Үндэслэл

Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн хариу арга хэмжээ авахад анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрт амьдарч байгаа үндсэн, түр оршин суугч болон явуулын хүн амын бүртгэлд үндэслэн "хаалга баригч"-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн коронавируст халдвар (COVID-19)-ыг эрт илрүүлэх, шаардлагатай оношилгоо, эмчилгээнд хугацаа алдалгүй хамруулах, зөвлөгөө өгөх, эрсдэлт бүлгийн хүн амыг хянах, халдварын сэргийлэлт хяналт хийх, түүнчлэн эмнэлгийн ачааллыг бууруулах чухал үүрэгтэй. [1,2]

Хоёр. Зорилго

Эрүүл мэндийн анхан шатны байгууллага (ЭМАШБ)-нь коронавируст халдвар (COVID-19)-ын үед сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх, хугацаа алдалгүй хянах, үр дүнтэй, аюулгүй, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг гэрээр тасалдуулахгүй үзүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

Гурав. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангахад удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын бэлэн байдал

3.1.1. Байгууллага өөрийн байгууллагын чадавхийг үнэлэн, хүн амын судалгаанд үндэслэн коронавируст халдварт өртөх эрсдэлт бүлгийн хүн амын тооцооллыг гарган, өөрийн байгууллагын тусламж үйлчилгээний төлөвлөлтийг гаргана.

3.1.2.Төлөвлөлтөд нэн шаардлагатай дэд бүтэц, хүний нөөц, харилцаа холбоо, тоног төхөөрөмж, шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэгцээ болон бусад нөөцийг тодорхойлно.

3.1.3.Шуурхай хариу арга хэмжээний 2-3 багийг ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын дагуу зохион байгуулна.

3.1.4. ЭМБ-д хандсан иргэнээс сэжигтэй тохиолдол илэрсэн үед шуурхай хариу арга хэмжээний баг ажиллах, тухайлбал бусад өвчтөнүүд, ар гэрийг бүртгэх, зөвлөгөө өгөх, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг ажлыг гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг гаргаж холбогдох албан тушаалтнаар батлуулсан байна.

3.1.5 Тусгайлан бэлдсэн нэмэлт байранд ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг гаргаж баталгаажуулсан байна.

3.1.6. Коронавируст халдвар (COVID-19) хүн амын дунд өргөн тархсан үед нэмэлтээр сайн дурааараа дайчлагдан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, резидент эмч, оюутнуудын судалгааг Эрүүл мэндийн газартай зөвшилцөн гаргасан байна.

3.1.7. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах, эмчлэх өрөөг ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу зохион байгуулна.

3.1.8. Орон нутгийн удирдлагуудтай хамтран өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлж болохуйц нэмэлт байруудыг сонгон, бэлтгэл ажлыг хангана.

- Суманд эхийн амрах байр, сургуулийн дотуур байр, цэцэрлэг байж болно.
- Аймгийн төв, хотын дүүргийн хороодод сувилал, амралтын газар, зочид буудал, оюутны дотуур байр, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн байр байж болно.

3.1.9. Нэн шаардлагатай (дархлаажуулалт, эх, нярай, жирэмсний хяналт, эрсдэлт бүлгийн хяналт, яаралтай тусламж гэх мэт) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

3.2. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын бэлэн байдал

3.2.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын болон сайн дурааараа дайчлагдан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд коронавируст халдвар (COVID-19)-ын эмнэлзүйн шинж тэмдгийг таних, эрэмбэлэн ангилах, халдварын сэргийлэлт хяналт, хамгаалах хувцас хэрэгслийн зөв хэрэглээ, сэжигтэй болон өвчтэй хүмүүсийг тусгаарлах, олон нийтэд эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл хүргэх болон сэтгэл зүйн бэлэн байдлын сургалтанд хамрагдсан байна.

3.2.2. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа сэжигтэй тохиолдлын илрүүлэлт, сэжигтэй тохиолдлын тархвар судалгааны хуудас, магадлалтай тохиолдлын тархвар судалгааны асуумж, батлагдсан тохиолдлын тархвар судалгааны хуудас, батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын тархвар судалгааны хуудас зэргийг хувилан олшруулж, нөөцийн бэлэн байдлыг хангах ба хэрхэн ашиглах, бөглөх талаар мэдлэгтэй байна.

3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдал

3.3.1. Нэн тэргүүнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн жагсаалтыг гаргаж шинэчилсэн байна. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн бэлэн байдлыг хангана

3.3.2. Халуун хэмжигч, пульсоксиметр, даралтын аппарат, чагнуур, хэл дарагч, шинжилгээний сорьц авах ариутгасан бамбар, хуруу шил, цэр цуглуулах сав зэргийг бэлтгэсэн байна.

3.3.3. Тохиолдлын бүртгэл мэдээлэл, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтанд цахим эрүүл мэндийн технологи (мобайл технологи, зайн оношилгоо эмчилгээний технологи, цахим эрүүл мэндийн бүртгэл, дижитал тоног төхөөрөмж)-ийг ашиглаж болно.

3.4. Мэдээлэл, харилцаа холбооны ба олон нийтийн оролцооны бэлэн байдал

3.4.1. Мэдээллийн 24 цагийн үйл ажиллагаатай (нээлттэй утас, эрүүл мэндийн төвийн цахим хуудас, мэдээллийн самбар, үгэн мэдээллийг дамжуулах урсдаг самбар) бэлэн байдлыг хангана.

3.4.2. Олон нийт, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнг хүн амыг эрүүл мэндийн мэдээллээр хангах, түүнчлэн хавьтлын судалгааны үйл ажиллагаанд татан оролцуулах бэлэн байдлыг хангана.

Дөрөв. Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээ

Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээ буюу сэжигтэй тохиолдлын илрүүлэг, эрэмбэлэн ангилал, эмнэлзүй, тархвар судлалын үнэлгээ, тусгаарлалт, эмчилгээ, хяналтын менежментийг энэ тушаалын 2 дугаар хавсралтын дагуу үзүүлнэ.

4.1 Сэжигтэй тохиолдлын илрүүлэг, эрэмбэлэн ангилал

4.1.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад **нээлттэй утсаар дуудлага өгсөн** хүнийг коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдол гэж үзвэл дараах арга хэмжээг авна.

4.1.1.1. Сэжигтэй тохиолдлыг илрүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн байгууллагынхаа шуурхай арга хэмжээний багт мэдэгдэнэ.

4.1.1.2 Шуурхай хариу арга хэмжээний багийг өвчтөний гэрт очтол тухайн иргэний халууныг хэмжүүлж, биеийн байдал болон эмнэлзүйн шинж тэмдгүүдийг асууж, зөвлөгөө өгнө. Мөн өөрийгөө болон хавьтлуудыг тусгаарлах боломжийн талаар зөвлөнө.

4.1.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад **өвчтөн өөрөө ирсэн тохиолдолд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.2.1 Хөтөч ажилтан эмнэлгийн байгууллагаар орж ирж буй бүх үйлчлүүлэгчийг эрэмбэлж, томуу томуу төст өвчин, амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг, хамт яваа хүний хамт тусгаарлах өрөө рүү чиглүүлнэ.

4.1.2.2 Коронавируст халдвар (COVID-19)-ын тохиолдлын тодорхойлолтын дагуу өвчтөнийг сэжигтэй тохиолдол гэж үзвэл эмч үзлэгээ түр зогсоон өрөөний цонхыг онгойлгож, хаалгаа түгжиж, орох гарах хөдөлгөөнийг хориглоно. Сэжигтэй тохиолдлоос 2 метрээс дотогш зайд харьцахгүй байхыг анхаарч, удирдлагад утсаар мэдээлнэ.

4.2.2.3 Тусгаарлах өрөөнд эмч үйлчлүүлэгчийн эмнэлзүйн шинж, биеийн байдлыг үнэлж, сэжигтэй тохиолдлын тархвар судалгааны хуудсыг бөглөнө.

4.2.2.4. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага мэдээ авсан даруй орох гарах хөдөлгөөнийг түр зогсооно. Сэжигтэй тохиолдолд үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, хамт яваа хүн, тухайн нөхцөлд үйлчлүүлж байсан иргэдийг бүртгэх, голомтыг халдваргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.2 Сэжигтэй тохиолдлын бүртгэл мэдээлэл, эмнэлзүй, халдвар судлалын үнэлгээ, тусгаарлалт, тээвэрлэлт, эмчилгээ, хяналт

4.2.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд сэжигтэй тохиолдлын бүртгэл мэдээлэл, эмнэлзүй, халдвар судлалын үнэлгээ, тусгаарлалт, тээвэрлэлт, эмчилгээ, хяналтын чиглэлээр дараах арга хэмжээг авна.

4.2.1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өрхийн эрүүл мэндийн төвүүд сэжигтэй тохиолдлын мэдээг Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийн 100 тоот утсанд мэдээлнэ.

4.2.1.2. Аймаг, сумын өрхийн эрүүл мэндийн төвүүд сэжигтэй тохиолдлыг , аймгийн шуурхай хариу арга хэмжээний багт мэдээлнэ.

4.2.1.3 ХӨСҮТ, аймгийн шуурхай хариу арга хэмжээний баг нь үнэлгээ хийх, сорьц авах, өвчтөнийг тээвэрлэх, тусгаарлах, эмчлэх, хянах арга хэмжээг авна.

4.2.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төвд сэжигтэй тохиолдлын бүртгэл мэдээлэл, эмнэлзүй, халдвар судлалын үнэлгээ, тусгаарлалт, тээвэрлэлт, эмчилгээ, хяналтын чиглэлээр дараах арга хэмжээг авна.

4.2.2.1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн шуурхай хариу арга хэмжээний баг сэжигтэй тохиолдлыг бүртгэж эмнэлзүйн үнэлгээ хийн, сорьц авч, зөөвөрлөнө.

4.2.2.2.Шуурхай хариу арга хэмжээний баг нь гэрт (гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх зааврыг баримтална), тухайн ЭМБ-д эсвэл тусгайлан бэлдсэн байранд тусгаарлах, эмчлэх, хянах арга хэмжээг тусламж, үйлчилгээ үзүүлэх эсэхийг аймгийн багтай зөвлөлдөн шийдвэрлэнэ.

4.2.2.3.Өвчтөнийг дараагийн шатлалын эмнэлэг рүү илгээх, тусгаарлах, эмчлэх, хянах арга хэмжээг аймгийн багтай зөвлөлдөн шийднэ.

4.3 Тохиолдлын онош баталгаажилт, мэдээлэл, хяналтын арга хэмжээ

4.3.1 Нийслэл, орон нутгийн түвшинд анхан шатны болон **лавлагаа шатлалын** эрүүл мэндийн байгууллагууд оношийн баталгаажилт, эмчилгээний үр дүнгийн талаарх мэдээлэл солилцох урсгалыг ханган ажиллана.

4.3.2 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд хавьтлын судалгаа, тандалтыг үргэлжлүүлнэ.

4.3.3 Лавлагаа шатлалын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж эдгэрч эмнэлгээс гарсан болон тусгаарлалт ажиглалтаас гарсан тохиолдлуудыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хяналтад шилжүүлнэ.

4.4. Нийтлэг мөрдөх заавар

4.4.1. Шуурхай хариу арга хэмжээний баг сэжигтэй тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх хугацааны турш ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалаар баталсан стандарт сэргийлэлтийн арга хэмжээг мөрдөнө.

4.4.2. Голомтын халдваргүйжүүлэлтийг ЭМС-ын 2020 оны А/188 тоот тушаалыг баримтлан хийж гүйцэтгэнэ.

4.4.3 Тоног төхөөрөмжийн халдваргүйжүүлэлтийг ЭМС-ын А/537 тоот тушаалыг баримтлан хийж гүйцэтгэнэ.

4.4.4. Сорьц авах, хадгалах, зөөвөрлөх, хүргүүлэхдээ ЭМС-ын А/135 тоот тушаалын "Коронавируст халдвар (COVID-19)-ын лабораторийн оношилгооны түр зааврыг баримтална.

4.4.5.Сэжигтэй тохиолдлын шинжилгээний хариу гартал гэр бүлийн гишүүд, ойрын хавьтлын бүртгэл хяналтыг хийж, гэртээ өөрсдийгөө тусгаарлах талаар зөвлөмж өгнө.

4.4.6. Сэжигтэй тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилтан шинжилгээний хариу гартал 14 хоног өөрийгөө тусгаарлана.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 17-өдрийн А/296 дугаар тушаалын хоёдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮДҮҮВЧ

ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТ

Нээлттэй утсаар дуудлага өгсөн тохиолдол

Сум, тосгоны өрхийн ЭМТ-д ирсэн тохиолдол

Сэжигтэй тохиолдол*:
- Шуурхай хариу арга хэмжээний багийг дуудна.
- Багийг иртэл өөрийгөө хэрхэн тусгаарлах, амны хаалт зүүх талаар зөвлөнө.
- Биеийн халууныг хэмжүүлж, биеийн байдал болон эмнэл зүйн шинж тэмдгүүдийг асууж, зөвлөнө.

Эмнэлгийн үүдэн хэсэгт хөтөч шинж тэмдгүүдийг илрүүлэн, өвчтөнг тусгаарлах өрөө рүү чиглүүлнэ.

Сэжигтэй бус тохиолдол: Үндсэн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Сэжигтэй тохиолдол*:
- Эмч үзлэгээ түр зогсоож, өрөөний хаалгыг дотроос нь түгжиж, гарах орох хөдөлгөөнийг хаана.
- Сэжигтэй тохиолдолд амны хаалт зүүлгэж, түүнтэй 1м-ээс дотогш зайд харьцахгүй байж, удирдлагад мэдэгдэнэ.

Сэжигтэй тохиолдлын мэдээллийн урсгал

- Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүд Халдварт өвчин судлалын үндэсний төвд мэдээлнэ.
- Аймгийн өрхийн эрүүл мэндийн төвүүд сэжигтэй тохиолдлыг аймгийн шуурхай хариу арга хэмжээний багт мэдээллийг хүргэнэ.

- Сум, тосгоны эрүүл мэндийн төв өөрийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний багт мэдээлнэ.
- Аймгийн шуурхай хариу арга хэмжээний багт мэдээллийг хүргэнэ.

Сэжигтэй тохиолдлын эмнэл зүй, тархвар зүйн үнэлгээ, мемененжмент

ХӨСҮТ, аймгийн шуурхай хариу арга хэмжээний баг нь өвчтөнд эмнэл зүй, тархвар судлалын үнэлгээ хийх ба сорьц авах, өвчтөнийг тээвэрлэх, тусгаарлах, эмчлэх, хянах арга хэмжээг зохион байгуулна.

- Сум, тосгоны эрүүл мэндийн төв дээр байгуулагдсан шуурхай хариу арга хэмжээний баг сэжигтэй тохиолдлыг бүртгэж эмнэл зүй, тархвар судлалын үнэлгээ хийх ба сорьц авах, хадгалах, зөөвөрлөх, хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
- Өвчтөнийг дараагийн шатлалд илгээх эсэхийг аймгийн багтай зөвлөлдөн шийдвэрлэнэ.

Дараагийн шатлалд илгээх

Дараагийн шатлалд илгээхгүй.
- Гэрт (гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх зааврыг баримтална);
- Тухайн эмнэлэгт эсвэл тусгайлан бэлдсэн байранд тусгаарлан, эмчлэх, хянах

- Тохиолдлын онош баталгаажилт, эмчилгээний үр дүнгийн талаарх мэдээллийг солилцоно.
- Хавьтлын судалгаа, тандалтыг үргэлжлүүлнэ

Эдгэрч эмнэлгээс гарсан; тусгаарлалт ажиглалтаас гарсан тохиолдлуудыг **анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хяналтад шилжүүлнэ.**

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04
дүгээр сарын 17-өдрийн А/ дугаар
ушаалын гуравдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ГЭРТЭЭ ТУСГААРЛАГДСАН ИРГЭДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ

Нэг. Үндэслэл

Коронавируст халдвар (COVID-19)-ын тусгаарлан ажиглалтаас гарсан болон эмчлэгдэн эдгэрсэн гэртээ тусгаарлагдсан иргэнийг хянах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

2.1. Гэртээ өөрийгөө үргэлжлүүлэн тусгаарлаж байгаа иргэнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн хяналт хийхэд удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангана.

2.2. Шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас аймаг, дүүргийн төрөлжсөн мэргэшлийн эмчтэй холбогдон зөвлөгөө, мэдээллийг шуурхай авах, Эрүүл мэндийн газарт өгөх үйл ажиллагааны мэдээллийн урсгалыг тодорхой болгож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.3. Гэртээ өөрийгөө тусгаарлаж байгаа иргэдэд тавьж буй эрүүл мэндийн хяналт, үр дүнгийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.

2.4. Гэртээ тусгаарлагдсан иргэний эрүүл мэндэд хяналт хийх үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулж байгаа иргэдийг холбогдох байгууллагад уламжилна.

2.5. Гэртээ тусгаарлалтад байгаа иргэний эрүүл мэндийн хяналтын болон үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийг 7 хоног бүрийн Баасан гарагт багтаан аймаг, нийслэлийн онцгой комисс, ХӨСҮТ-д өгнө.

Гурав.Өрх сум, тосгоны Эрүүл мэндийн байгууллага

3.1. Харьяалах нутаг дэвсгэрийн гэртээ өөрийгөө тусгаарлах иргэдийн мэдээлэлд үндэслэн иргэнийг хянах эмч, сувилагчийг томилон, тусгаарлагдсан иргэн болон гэр бүлийн бусад гишүүдийг бүртгэн авна.

3.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч сувилагч нь тусгаарлагдсан иргэнтэй утсаар холбогдон биеийн байдал, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгийг тодруулж, эргэн холбоо барих нээлттэй утасны дугаарыг тэмдэглүүлнэ.

3.3. Эрүүл мэндийн талаар мэдээлэх хугацаа, халдвар хамгааллын дэглэм, ажиглалтад байх иргэн болон түүний гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг сануулж, утсаа байнга нээлттэй байлгах талаар анхааруулна.

3.4. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан иргэдийн мэдээлэл зөрүүтэй, хаяг дээрээ байхгүй тохиолдолд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, сум, хорооны цагдаагийн хэсэгт мэдээллийг өгнө.

3.5. Иргэн өдөрт 2-оос доошгүй удаа биеийн халуунаа хэмжиж "Өдөр тутмын хяналтын хуудас"-нд тэмдэглэн, ямар нэгэн зовиур илэрсэн, зөвлөгөө авах шаардлага гарсан даруйд хяналтын эмчид утсаар хандана.

3.6. Эрүүл мэндийн талаарх мэдээллээ өгөхгүй байгаа иргэнийг утсаар тодруулж, утас нь холбогдохгүй тохиолдол бүрийг тэмдэглэн сум, хорооны цагдаагийн хэсэгт мэдэгдэнэ.

3.7. Тусгаарлагдсан иргэнд халуурах, хоолой хөндүүрлэх, хуурай ханиалгах, ядарч сульдах шинж тэмдэг илэрвэл анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн ХӨСҮТ-ий 100 болон 80086829 дугаарын утсанд хандана.

3.8. Коронавируст халдвар эмчлэгдэн эдгэрсэн гэртээ тусгаарлагдсан иргэнийг холбогдох журмын дагуу товлолт хугацаанд нь ХӨСҮТ-д мэдээлэл өгч вирусийн шинжилгээнд хамруулна.

3.9. Иргэнээс утсаар болон нийгмийн сүлжээгээр хандсан хүсэлтийн дагуу ХӨСҮТ болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч шаардлагатай зөвлөгөө, шинж тэмдгийн эмчилгээ, анхаарах асуудлын талаар хариу өгнө.

3.10. Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, харьяа аймаг, дүүргийн эмнэлгийн холбогдох мэргэшлийн эмчийг иргэнтэй холбон зөвлөгөө, мэдээлэл өгүүлнэ.

3.11. Гэртээ тусгаарлагдсан иргэдэд эрүүл мэндийн хяналт хийж, зөвлөгөө, мэдээлэл өгч, шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамруулсан талаарх мэдээллийг харьяа Эрүүл мэндийн газарт өгнө.

3.12. Нэн шаардлагатай тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн гэрээр үзлэг, шинжилгээ, эмчилгээг хийнэ.

Дөрөв. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг

4.1. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага анхан шатны эрүүл мэндийн байгууллагын дуудлагыг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн эмчтэй холбон иргэнд утсаар зөвлөгөө өгөх боломжоор хангана.

4.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн дуудлагын дагуу аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн мэргэшлийн эмч тусгаарлагдсан иргэнээс асуумж, биеийн байдлын талаарх мэдээлэл авч, зөвлөгөө мэдээллийг утсаар өгнө.

4.3. Тусгаарлалтад байгаа иргэнд тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдолд орон нутагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт, нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төвд хэвтүүлэн эмчилгээнд хамруулна.

4.4. Аймаг дүүргийн эрүүл мэндийн байгууллага, Халдварт өвчин судлалын үндэсний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, амаржих газарт төрөлжсөн мэргэшлийн эмчийн дуудлага өгч, тусгаарлагдсан иргэнд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.5. Гэрээр тусгаарлагдан, үргэлжлүүлэн ажиглалтад байгаа жирэмсэн эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг "Коронавируст халдварын үед жирэмсэн эмэгтэй, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний зохицуулалтын түр журам"-ын дагуу үзүүлнэ.

4.6. ХӨСҮТ нь гэртээ тусгаарлагдсан иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаарх улсын хэмжээний 7 хоногийн нэгдсэн мэдээллийг Эмнэлгийн тусламжийн газарт өгнө.

ooOoo